



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Эцэг эх, асран хамгаалагчдын
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын хавсралтын 5.1 дэх заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр баримтлах бодлого чиглэлийг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий Эцэг эх, асран хамгаалагчдын зөвлөлийг шинэчлэн байгуулсугай.

2.Эцэг эх, асран хамгаалагчдын зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, тухай бүрд тайлагнаж ажиллахыг Эцэг эх, асран хамгаалагчдын зөвлөл (Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга)-д даалгасугай.

4.Энэ захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны 38 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (П.Баянбаатар)-нд даалгасугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР


Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 2025 оны 03 дугаар сарын 12-ны
өдрийн 24 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДЫН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: ИТХ-ын Ажлын албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга
- Гишүүн: ИТХ-ын Ажлын албаны Удирдлага, зохион байгуулалтын хэлтсийн Төлөөлөгчийн үйл ажиллагаа, сургалт хариуцсан мэргэжилтэн
- Нарийн бичгийн дарга: ИТХ-ын Ажлын албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн Иргэний оролцоо, олон нийттэй харилцах мэргэжилтэн

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 2025 оны 03 дугаар сарын 12-ны
өдрийн 24 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Эцэг эх, асран хамгаалагчдын зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/ нь Хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр баримтлах бодлого чиглэлийг байгууллагын хэмжээнд зохион байгуулах, хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эцэг эх хүүхдийн харилцаа, нийгмийн хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах сайн дурын асран хамгаалагчдын төлөөлөл мөн.

1.2.Зөвлөл нь дарга, гишүүд, нарийн бичиг гэсэн 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнийг байгууллагын хамт олны саналд тулгуурлан 1 жилийн хугацаагаар Хурлын даргын захирамжаар байгуулна.

1.3.Зөвлөлийн дарга зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бөгөөд зөвлөлийн гишүүдийн ажил үүргийг хуваарилах, бусад байгууллага зөвлөлтэй харилцаж, Хурлын даргын өмнө үйл ажиллагаагаа тайлагнана.

Хоёр.Зөвлөлийн үйл ажиллагаа

2.1.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь байгууллагын хэмжээнд хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр зохион байгуулах сургалт, үйл ажиллагаа байна.

2.2.Зөвлөл нь байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхдийн судалгаанд үндэслэн тэдэнд чиглэсэн дараах үйл ажиллагааг үе шаттай төлөвлөн зохион байгуулна.

2.2.1.Гэр бүл, хүүхэд хөгжил, хамгааллын талаарх сургалт, нөлөөллийн арга хэмжээг асран хамгаалагчдад зохион байгуулах;

2.2.2.Байгууллагын ажилтны тоо, цар хүрээ, боломжид тулгуурлан хүүхдийн хөгжлийг дэмжих ажлыг санаачлан хэрэгжүүлэх;

2.2.3.Олон Улсын гэр бүлийн өдөр болон Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд тэдэнд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах;

2.2.4.Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор цэцэрлэг, бага ангийн хүүхэдтэй эцэг эх,

асран хамгаалагчдад Хөдөлмөрийн хуулийн дагуу богиносгосон цагаар ажиллах нөхцөл бүрдүүлэх, хүүхдийнхээ эцэг эхийн хуралд оролцох, сургууль орчмын эргүүл хийх боломжоор хангах;

2.2.5.Эцэг эх, асран хамгаалагч ажилтнуудад эцэг эх, асран хамгаалагчдын үүргээ биелүүлэх, хүүхдэдээ халамж анхаарал тавих боломж олгох талаарх саналыг байгууллагын хэмжээнд мөрдөх дүрэм, журамд тусгуулах;

Гурав.Бусад

3.1.Зөвлөлөөс зохион байгуулах үйл ажиллагааны зардлыг байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.

3.2.Зөвлөл нь зохион байгуулах ажлын санал шийдвэрээ байгууллагын удирдлагуудад танилцуулж шийдвэрлүүлэх бөгөөд зохион байгуулсан ажлын тайланг тухай бүр тайлагнана.

3.3.Зөвлөл нь зохион байгуулсан ажлаа байгууллагын нийт албан хаагчдад нээлттэй мэдээлж, сурталчилна.